



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2024

4-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

www.bogdbank.com



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



НОГООН САНХҮҮЖИЛТ

Бид тайлант хугацаанд Богд Банк нь жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ), тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчид болон ногоон санаачилгуудыг тууштай дэмжих зорилгын хүрээнд хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих эрхэм зорилготой Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO)-тай 20 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулж, стратегийн хамтын ажиллагаагаа эхлүүлээ. Энэхүү санхүүжилтийн 30-аас доошгүй хувь нь байгаль орчинд ээлтэй ногоон төслүүдэд, үлдсэн 70 хувь нь хөдөө аж ахуй, залуучууд, эмэгтэйчүүдийн ЖДҮ-г дэмжихэд зарцуулагдах юм.



**BOGD BANK AND FMO
BEGINS COOPERATION TO SUPPORT
SMEs AND GREEN PROJECTS
IN MONGOLIA**

НОГООН ОРЧИН

Богд банк нь Намрын мод тарих өдөр” арга хэмжээг Банкны салбарынхан хамтдаа зохион байгуулав. Монгол Улсад банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жил, Ойн салбарын 100 жилийн ойг тус тус тохиолдуулан Монгол банк, Монголын банкны холбоо, арилжааны банк, Тэрбум мод сан зэрэг байгууллагуудын төлөөлөл Гачууртад байрлах Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн (International Garden of Mongolia)-нд энэ хаврын мод тарилтаар нарс, шинэс, гацуур зэрэг 1,000 гаруй төрлийн мод тарьсан бол намрын тарилтаар нийт 6,000 ширхэг навчит болон шилмүүст мод тарьснаас гадна 1,000 гаруй шилмүүст мод нэмж тарилаа.



НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ

Бид нөөцийн хэмнэлтийн хүрээнд жил бүр шинэ санаа санаачилгыг гарган ажиллахыг зорин ажилладаг бөгөөд, цаасны хэрэглээ, хог хаягдлыг бууруулахаар ажилдаг билээ. Бид үүнийхээ хүрээнд “Онлайнаар харилцагч бүртгэх” үйлчилгээг банкны салбартаа нэвтрүүлсэн анхны банк билээ. Тус үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагч салбарт ирж бүртгүүлэх анхан шатны 5 хуудас цаасны хэмнэлтийг 100% онлайнаар бүртгүүлэх боломж бүрдсэн.



ИЛ ТОД БАЙДАЛ

Богд банк нь Тогтвортой санхүүжилтийн хүрээнд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, зээл олголтод Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хэрэгжүүлж байна. Бид харилцагчдадаа “НОГООН” тодорхойлолттой дараах зээлийн бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэн санхүүжилтийг түлхүү олгож байна.

БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

НОГООН ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛ

- Цахилгаан халаагуур
- Дулаалгын материал
- Бүх төрлийн унадаг дугуй
- Цахилгаан скүүтер
- Цахилгаан мотоцикл
- Эко ариун цэврийн байгууламж
- Сайжруулсан зуух
- Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн

БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ
ЦАЛИНГИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ОРЛОГОТ ОЙРГОНД ЗЭЭЛИЙН ХАМГИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ

10th ANNIVERSARY | **MGFC** *green* ACTING FOR CLIMATE SOLIDARITY

ДУЛААН ШИЙДЭЛ

Хэрэв та байшингаа дулаалахаар шийдсэн бол "Дулаан шийдэл" зээлийн бүтээгдэхүүнийг танд санал болгож байна.

www.bogdbank.com

10th ANNIVERSARY | **БОГД БАНК**

Бизнес эрхлэгч
ЭМЭГТЭЙ
танд зориулсан зээл

Бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулахад зориулсан зээл.

www.bogdbank.com